

Их бодь мөрийн зэрэг бүтээлийн монгол орчуулгууд

Арилдийн БУРМАА*
Япон улс, Кобэ хот,
Гадаад Хэлний Их Сургууль

Received: Sep 1, 2024

Revised: Oct 7, 2024

Accepted: Oct 23, 2024

Хураангуй: Их бодь мөрийн зэрэг нь гэлүгвагийн шашныг үндэслэгч богд Зонхава (1357-1419)-ын зохиол юм. Уг бүтээлээрээ Төвөдийн буддизмын гол онцлог бүхий “Мөрийн зэрэг” үзлийг айлдсан байдаг билээ. Энэтхэгийн Викрамашила хийдийн хамба лам асан Атиша (982-1054) Төвөдөд залагдаж ахуй хугацаандаа туурвисан Бодь мөрийн зул зохиолоороо анх “Мөрийн зэрэг” үзлийн суурийг тавьсан гэдэг. Уг үзлийг эцсийн шатанд хөгжүүлсэн боловсронгуй хэлбэр нь Их бодь мөрийн зэрэг гэж хэлж болно. Уг бүтээл монгол хэлнээ олонтоо орчуулагдаж ирсэн хэдий ч хэн хэзээ орчуулсан хэдэн төрлийн орчуулга байдаг хийгээд тэдгээр нь одоо хаана байгаа нь тодорхойгүй байсаар байсан юм. Энэхүү судалгаагаар нийт 7 төрлийн орчуулга буйг олж тогтоов.

(1) Алтангэрэл увшийн орчуулга (орч. он 1655)

(2) Зая бандидын шавь Дагийн орчуулга (орч. он 1662-1670)

(3) Урадын мэргэн равжамба Гунгаажамцын орчуулга (орч. он XVII зууны сүүл хагас)

(4) Зонхавын сүмбүм дэх орчуулга (орч. он 1730 оны сүүл хагас)

(5) Лувсанцэнпэлийн орчуулга (Lubsangcempil, 1761-1834) (орч. он 1812)

(6) Галсанжамбын орчуулга (1816-18??) (орч. он 1870)

(7) Т.Булганы орчуулга (1959~) (орч. он 2004-2007)

Энд эдгээр орчуулгын хадгалагдаж буй газар, орчуулагч, орчуулагдсан оны талаар хэрхэн тодруулсан хийгээд хоорондын холбоо хамаарлыг авч үзлээ. Орчуулагч нь тодорхойгүй төгсгөлийн үггүй эхүүд ч байгаа тул мөргөлийн шүлгээр харьцуулав.

Түлхүүр үг: Их бодь мөрийн зэрэг, Богд Зонхав, Мөрийн зэрэг

* © А.Бурмаа 2024

Email: burmaa_gej@yahoo.com

About the Seven Mongolian Translations of Lamrim Chenmo

BURMAA Arildii
School of Foreign Language,
Kobe City, Japan

Abstract: *The Mongolian translation of Tsongkhapa's (1357-1419) Lamrim Chenmo was carried out several times. However, the exact number of translations, when they were done, and who the translators were remained unclear. Through my research, I have confirmed the existence of seven different translations. Based on colophons and historical sources, I was able to estimate the dates of these translations. Furthermore, by comparing the dedication verses (verses of homage) present in all versions, including manuscripts and woodblocks without colophons, I was able to analyze the relationships and influences among the translations, even when the translators could not be definitively identified.*

Key words: *Lamrim Chenmo, Tsongkhapa, The Mongolian translation of Lamrim Chenmo*

1. Удиртгал

Монголд Төвөдөөс буддизмыг нэвтрүүлэхэд Сажав⁵⁰, Гармава⁵¹-ын урсгалын лам багш нар үүрэг оролцоотой байсан түүхтэй. Гэвч аажмаар Гэлүгва⁵² урсгал голлох байрыг эзлэх болж өдгөө Монголын хамгийн том хийд болох Гандантэгчэнлин хийд гэлүгвийн сургалтын уламжлалаар явж байна (Бурмаа, 2019: 185). Энэ бүхний үр дүнд гэлүгваг үндэслэгч Богд Зонхавын нэрт бүтээл “Их бодь мөрийн зэрэг” зохиол монгол хэлэнд олонтоо орчуулагдаж байжээ. Гэсэн хэдий ч өнөө хэр дорвитой судалгаа байхгүй байна. “Их бодь мөрийн зэрэг” зохиолын монгол орчуулгын талаар зөвхөн уг эхтэй таарсан нэг нь дор дороо танилцуулсан (Лувсанбалдан, 1975: 158., Бямбаа, 1997: 33, Sečenbilig, 2018: 31) байдалтай байдгаас нийт хэдэн орчуулга байгаа хийгээд хэдэн онд хэний орчуулснаар хэрхэн дэлгэрч байсан, хоорондоо ямар харилцаа холбоотой гэх мэт олон асуудал тодорхойгүй хэвээр байсан юм.

2. Судалгааны арга зүй

Энд миний бие “Их бодь мөрийн зэрэг” зохиолын монгол орчуулгын материалуудыг чадах чинээгээр олж судалснаа толилуулъя. Орчуулгуудын он цагийг төгсгөлийн үг болон түүхэн баримтад тулгуурлан тогтоов. Товчилсон нэрээр НМЖ (2a), ZSMЖ (4d), ZSMЖ (4e), GMЖ (6), GMЖ (6a)⁵³ гэж энд

⁵⁰ sa skya pa

⁵¹ karma pa

⁵² dge lugs pa

⁵³ Товчилсон нэрийг хуудас 49-51 дэх сурвалж бичгийн мэдээний эмхэтгэлээс лавлана уу.

тэмдэглэгдсэн орчуулгын таван эх төгсгөлийн үггүй, амарлин оршихуй ба үлэмж үзэхүйн бүлэг дутуу (3 төрөлхтний бүлэг) юм. Иймээс эхний хэсэг буюу мөргөлийн шүлгийн хүүрэнд бүх эхүүдээ хооронд нь харгуулж, хэн хэн орчуулсан, нийт хэдэн төрлийн орчуулга байгаа хийгээд төгсгөлийн үггүй эхүүд хэний орчуулга болохыг тодрууллаа. Одоогийн байдлаар 7 төрлийн орчуулга байгааг олж тогтоосон болно.

3. Судалгааны хэсэг

3.1. “Их бодь мөрийн зэрэг”-тэй холбогдох мэдээ сурвалжид үндэслэн орчуулагчид, орчуулагдсан он цагийг тогтоох нь

(1) Алтангэрэл увшийн орчуулга (1655)

Монголын Үндэсний номын санд No.4049/96 дугаартай судрын 378 хуудас орчуулга байна. Төгсгөлийн үгийг галигаар сийрүүлбэл,

ere boyda Činggis qayan-u altan uray-dur törügsen,
 erke kücün yeketü Včirai qayan-u ači anu boluysan,
 erten-ü irüger-iyer erketü qutuy-tu-yin ečig(e) bolun učiralduysan,
 erdeni sasin tör(ü)-yi engke-ber manduyuluyci Včirai tüsiyetü qayan.
 asaraqui nigülesküi sedkil inü aburayči Qongsim bodisung metü,
 ariyun süsüg bisirel inü nasuda ...layči bodisung metü,
 arıadal ügei ünen-i ügüleküi anu arsis-un qayan metü,
 arban buyan-iyar amitan-i uduridqui anu Čagırvad qayan metü bölüge.
 teyimü sayin aldar-tu tere boyda-yi törül yegüdkegsen dur-i
 tesčü yadan qutuy-tu boyda nom-un qan terigüten quvaray-ud ba,
 tegsi bisirel-tü čoytu eke Bunidara qong tayiji Dayiching terigüten,
 tengsel ügei olan süsüg ten-i orčiyul kemen duradyaysan dur-i.
 boyda tsongkhaba kemen bügüde de sayitur aldarsiy-san
 boyda bügüde merged-ün orui-yin čimeg (378a] boluysan tere boyda-yin,
 бүкүй sudur saštir-un onisun-u nigen-e quriyaju nomlaysan,
 būrin ĳurban arad-i bodi mör-dür uduridqu-yin ĳerge egüni.
 Altan gerel ubasi alĳiyaqu čileqüi-ben tala ülü qaran,
 aliba ese medegsen-iyen nom-un qan-dur öčijü asayuyad,
 alıasal ügegüiy-e ö(e]dür šöni ürgüljid kičiyen orčiyulĳu tegüskebei bi,
 aldal ügei bičigči Maidari ĳimali qoyar asuru ilübtülen bicibei. (AMĳ,

277b21-378a36)

Энд “Эр мэргэн Их Эзэн Чингис хааны алтан урагт төрж, Очирай хааны ач нь болсон, эртний ерөөлөөр эрхт хутагтын эцэг болон учралдсан, эрдэнэ шашин төрийг энхээр мандуулагч Очирай түшээт хан” хэмээн Түшээт хан Гомбодоржийн талаар энэ төгсгөлийн үгэнд өгүүлсэн байдаг. Хожим анхдугаар дүрийн Жэвзүндамба гэгдэх болсон Занабазар (1635-1723) гэгээний эцэг

Гомбодорж 1655 онд таалал төгсөхөд түүний хойдын буянд зориулж, олны хүсэлтээр Алтангэрэл увш (Дамдинсүрэн, 1984: 19, Ганзориг., Бямбаа, 2017: 5) *Их бодь мөрийн зэрэг* бүтээлийг монгол хэлэнд орчуулсан тухайгаа мөн дурдсан байгаа учир уг орчуулгыг 1655 оны орчим хийжээ гэж үзэж болох юм.

(2) Зая бандидын шавь Дагийн орчуулга (1662-1670)

Тод үсгийн орчуулга *Их бодь мөрийн зэрэг* (1) Монголын Үндэсний номын сан, (2) Ховд их сургуулийн номын сан, (3) Гандангийн номын сан гэсэн 3 газар байгаа тухай мэдээ бий боловч, эдүгээ алинд нь ч үгүй байна. Монголын Үндэсний номын санд No.8541 тод үсгийн Их бодь мөрийн зэрэг гэж дугаарлагдсан, хавтсан дээрээ *bodi mör-ün jerge, tod-bar* гэж худам монголоор бичсэн ном хадгалагдаж байх авч, төгсгөлийн үгийг үзвэл “*enetkeg yin üile-dügči Dharma Sri Bhadra tai. kelmürči bande Čoy lhünpü körbүүлүн шүүгед siidken bayulyabai. (446a34-37)*” гэсэн байгаагаас Бодь мөрийн зэрэг биш болох нь тодорхой байна.

Ховд их сургуульд байсан гэх тод гар бичмэлийн фото эх Ховд их сургуулийн багш А. Батсуурь агсанд байсан юм. Тэр фото эхээс эхний 5, сүүлийн 2 хуудсыг үзүүлэв. Төгсгөлийн үггүй, 233 судрын хуудас гар бичмэл ажээ. “*yeke töröl-kitüin zamayin nomalasan küsekü setkil sudulqutai ilayuyсан köükeni yürü-yin yabudal-du surqu zamayin ulami nomloči dүsbai. (Khovd tod YBMJ 233b13-17)*” хэмээн төгсөж байгаагаас 3 төрөлхтний мөрийн зэрэг хүртэлх эх байна.

Гандангийн номын санд 59,7x15,5 см хэмжээтэй, хар улаан шунхаар бичигдсэн 471 судрын хуудас тод гар бичмэл орчуулга хадгалагдаж байсан тухай аман ба бичгийн мэдээ байна (Лувсанбалдан, 1975: 185). Х.Лувсанбалданы галигласнаар төгсгөлийн үгийг сийрүүлэв.

törö nereyini ende yosučilan barin üiledügči tabtayar üre boluyсан todorqoi biligēr qoyor janggiyin yosuni yambarčilan Sengge dgra ’dultei. tungyalii sүjүgēr yurban erdeni takiүči Če dbeng rgyalmo qoyor kürbүүл kemēgsen-dү. tōmilon kürbүүлbe Rab ’byam Ја ya-yin ečүs šabi Daki neretү dgeslүng. (Лувсанбалдан, 1975: 158)

Орчуулгыг дуртгагч буюу захиалагч болох Сэнгэ Радла Зая бандидатай машид дотно нэгэн байсан байна⁵⁴. Тиймээс Зая бандидыг амьд сэрүүн ахуйд

⁵⁴ Энд орчуулгын захиалагч Сэнгэ Радла (16.-1670, ширээнд 164?-1670) гэдэг нь Зүүн гарын хаант улсын хоёрдугаар захирагч Баатар Хунтайж (1...-1653, ширээнд 1634-1643) хааны тав дахь хүү бөгөөд төрсөн дүүгийнх нь зургаа дахь хүү нь Галдан (1644-1697; ширээнд 1671-1697) хаан юм. Нөгөө нэг дурдагч Цэвээн Жалмо бол Сэнгэ Радлагийн эхнэр ажээ. Хосууд Буддын шашинд гүнээ итгэдэг байсан бөгөөд 1661 онд Зая бандидыг нас барахаас нэг жилийн өмнө мөн орчуулга хийлгэхээр хүссэн байдаг. Зая бандида 1662 онд Төвөдөд морилох үеэр нь Үсэн Саамар гэдэг газар гэртээ буулган 12 хоног ном айлдуулж аваад 100 толгой адуугаар өглөг өргөж байжээ. Мөн Зая бандидыг нас барснаас хойш хоёр жилийн дараа буюу 1664 онд Зая бандидын орчуулсан судруудыг хуулж, цуглуулах есөн хүнийг томилон явуулж байсан гэдэг.

нь түүний шавьд хандан захиалга өгөх явдал гарахгүй болов уу гэдэг таамаглал дээр үндэслэн энэхүү орчуулга Ойрадын Зая бандида нас барсан 1662 оноос, захиалагч Сэнгэ Радлагийн нас барсан 1670 оны үеийн орчуулга болов уу гэж үзэж болохоор байна.

Даги гэдэг нь ёгт нэр бололтой. Энэ нэрээр орчуулагчийн талаар тодруулж чадсангүй. Зая бандидын эцэс шавь гэж бичсэн байгааг лавтган илүү дэлгэрүүлэх шаардлагатай. Мэргэн лам Гаваанлоорой гэх хүнийг *Их бодь мөрийн зэрэг* бүтээлийг монгол хэлэнд орчуулсан тухай Гоман дацангийн түүхэнд дурдсан байдаг (2003: 430-434). Гаваанлооройг орчуулагч Даги мөн болов уу гэж Х.Бямбажав таамаглаж байна (Ядамжав, 2017: 401). Ийн тодын орчуулгын эх 3 орчим байна. Хэдэн төрлийн орчуулга байгааг тодруулах хэрэгтэй.

(3) Урадын мэргэн равжамба Гунгаажамцын орчуулга (1654-1703)

Энэ орчуулгын 3 эх бий гэх мэдээ байна. Миний бие 1986 онд хуулсан гэх гар бичмэл (Өвөрмонголын номын сан No.B/209-1/1-ээс эхлэх 10 дэвтэр) олж үзэв. Төгсгөлийн үгээс

egün-i mongyul döcün yisün jasaγ bügüd-yin. kümün-ber orui-yin čimeg bolγan bariγsan toyin blam-a kemen. qamuy жүг-үд-түр aldarsiγsan tere yeke boyda-ber. orčiγul kemen duradqui jarliγ orui-dur soyurqaysan tegün-e sitüged. jarliγ tegün-e бүтүкүйин tulada Töbed-ün yeke ayalγu-ača 'bro ba mergen Rab 'byams pa Kün dga' rgya mtsho kemekü ber. orčiγul-un üiledbei tegüni kičiyen bičigsen bičigči anu Urad-un. dges lüng Sis rab rgya mtsho kemekü tere ber sayitur bičibeī. (RMJ. 1456b, No.B/209-10)

Орчуулагч нь Брова мэргэн равжамба Гунгаажамц⁵⁵ (1654-?), бичээч нь Урадын гэлэн Шаравжамц⁵⁶ болох тухай төгсгөлийн үгэнд дурджээ. Сэцэнбилигийн үзэж буйгаар дурдагч нь Нэйж тойн хутагтын хоёрдугаар дүр Агваанлуvsандамбийжалсан (1671-1703) юм. Нэйж тойн хутагтын хоёрдугаар дүр 1703 онд таалал болсон байдаг. Хэрэв дуртгагч Нэйж тойн хутагтын хоёрдугаар дүр мөн бол Гунгаажамц 1654 онд төрсөн учраас *Их бодь мөрийн зэрэг*-ийн Равжамба Гунгаажамцын орчуулгын орчуулагдсан он цаг нь 1654 оноос Нэйж тойны нас барсан 1703 оны хооронд байж таарна.

Энэ нь орчуулгыг дурдагч Сэнгэ Радла Зая бандидтай их дотно харилцаатай байсныг илтгэж байна. (Лувсанбалдан, 1975: 140)

⁵⁵ 'bro ba mergen Rab 'byams pa kün dga' rgya mtsho

⁵⁶ dges lung sis rab rgya mtsho

(4) Зонхавын сүмбүм дэх орчуулга

Данжуурын гарчигт Жанжаа хутагтын хоёрдугаар дүрийн сүмбүм 7 боть, Богд Зонхавын сүмбүм 20 ботийг Бээжин барын Данжуурт дагуулж хэвлэсэн тухай дурдсан байдаг. Гэвч бээжин барын Данжуур хадгалагдаж буй гурван газрын⁵⁷ алинд нь ч сүмбүм байхгүй байна. Киотогийн Их сургуулийн номын сангийн Ханэда салбарт шунхан барын Зонхавын сүмбүм 9 боть, Жанжаа хутагтын сүмбүм 2 боть хадгалагдаж байна. Тэр бол одоогоор бидний олж мэдсэнээр бээжин барын шунхан сүмбүмээс үлдсэн ботиуд юм. Харамсалтай нь тэнд *Их бодь мөрийн зэрэг* алга. *Бага бодь мөрийн зэрэг* байх авч нийт 253 хуудаснаас 235 (1b-235b) хуудас байх тул араасаа 18 хуудас дутуу ажээ. Ganjuur Danjuur (2014) хэвлэлд байгаа 2 сүмбүм бол бээжин барын Данжуурт дагалдаж асан шунхан сүмбүмүүд биш, үсгийг улаан болгон засаж хэвлэсэн хар бэхэн барын сүмбүмүүд юм. Ханэдад байгаа ботиудтай тулгаж үзвээс хар бэхэн бар хийгээд шунхан барын сүмбүм нь агуулгын хувьд ижил байна⁵⁸. Бээжин барын Данжуурт дагалдах төвөд хэлний сүмбүм дэх Ламримчүнва (*Бага бодь мөрийн зэрэг*) бүтээлийн төгсгөлийн үгээс бодь мөрийн зэрэгтэй холбоотой зарим бүтээлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. Тавдугаар Далай лам бичсэн тэрхүү төвөд хэлний төгсгөлийн үг монгол хэлнээ буухдаа мөн монгол орчуулгын талаарх мэдээллээр баяжсан байх магадлалтай. Гэвч Ganjuur Danjuur (2014) нь Зонхавын сүмбүмийн 2 ба 8 дугаар боть дутуу учир 2 дугаар боть болох *Бага бодь мөрийн зэрэг* бүтээлийг бид одоогоор үзэж чадаагүй байна. Успенский⁵⁹, Иноүэ⁶⁰ (2001) каталоогоос харахад Санкт-Петербургийн номын санд буй хар үсгийн сүмбүм нь бүрэн бололтой байна. Тэндээс *Бага бодь мөрийн зэрэг*-ийн төгсгөлийн үгийг үзэх боломжтой. Хар үсгийн сүмбүмийн орчуулсан огноог 5-р ботид 1738-1739 он, 18-р ботид 1738 он гэж бичсэн байдаг тул бүрэн эхээр нь 1730-аад оны сүүлчээр гарсан байх магадлалтай гэж үзэж болно (Бурмаа, 2019). Тиймээс сүмбүмд орсон эл орчуулгын орчуулагдсан огноог ч мөн 1730 оны сүүлээр гэж үзэх боломжтой юм. Ингээд бээжин барын төвөд эх Ламримчүнва буюу *Бага бодь мөрийн зэрэг*-ийн төгсгөлийн үгийг харъя.

⁵⁷ Монголын үндэсний номын сан (гарчиг бүрэн), Өвөрмонголын номын сан (гарчиг бүрэн бус), Өвөрмонголын Нийгмийн ухааны нийгэмлэгийн номын сан (гарчиг бүрэн бус).

⁵⁸ Богд Зонхава хийгээд хоёрдугаар дүрийн Жанжаа хутагтын хар үсгийн барын энэ 2 сүмбүм бол бээжин барын монгол данжуурт (1749) хамт хэвлүүлэхээр бэлдсэн монгол орчуулга нь бололтой. Зонхавын сүмбүмийг данжууртай цуг хэвлэх саналыг Манжийн төрд зүтгүүлж амжилтыг олсон авч 2 сүмбүмийн монгол орчуулгын ажлыг данжуурын баг гүйцэтгэсэнгүй. Угаас Данжуур гэдэг санскрит хэл дээрх Нагаржунай нарын буддист онолчдын бүтээлийн цуглуулга ба түүнд Төвөд хүний зохиол бүтээл хавсаргасан нь онцгой тохиолдол байлаа. Тиймээс орчуулгын ажил нь ч мөн санал гаргагч нарын толгой дээр буусан бололтой. Ямартаа ч тусгай баг орчуулжээ.

⁵⁹ Uspensky

⁶⁰ Inoue

Зонхавын сүмбүмийн хараахан дуусаагүй байгаа баруудыг шинээр сийлэх шаардлагатай байна гэж Дэвасанжаажамц урьдаас шавдуулж ирсний дагуу, 12 дугаар жарны усан туулай жил (1687) энэхүү Мөрийн зэргийн барыг Галданпунцаг сүмд бүтээхэд хянан шалгагчаар Yar 'brog нутгийн гэлэн Лодойдамба rTse skor нутгийн Гэлэн Лосолхайваа, Дашилин нутгийн Гэлэн Мрайвааванчиг нарын гурван хүнтэй, бичээч Галданданзан, Лувсанравжир, Цэрэндаржаа, сийлбэрч мужаан Дэлэг, Сүнбэдорж, Пунцаг, Чагнааванжил, Доржсванжил, Цэвээнбалдан, Сүндэр, Цан нарын хүн, Гунгаацэдэн Юлжал, Лүндэндорж, Зимчүнванбо, Вандан, Сүнмэбадма, модны мужаан Соном, Ухадимисанбуу-Одсэр, хэрэгцээт зүйлсээр хангагч Гямадаваацэрэн, Кашимэпа Сономноров нарын бүтээсэн Бага бодь мөрийн зэрэг бүтээлийн энэхүү төгсгөлийн үгийг Хор нутгийн бандида Жамьянгавааашинэн туурвиж, бичээчээр Балдан, Гармаа, Гаваангэлэг нар зүтгэв.⁶¹ (324a2-8)

Энэ төгсгөлийн үгэнд Бээжин барын Данжуурт дагалдах Зонхавын сүмбүмийн төвөд эхийн Бодь мөрийн зэрэг номлох бүтээлүүдийг тусгайлан модон бар бүтээж, засварласан тухай гардаг. 1687 онд модон бараа бүтээсэн газар нь Потала ордны өвөр бэлд орших Шол (zhol) барын өлгий Ганданпунцаг дацан ажээ. Тэгэхээр Бодь мөрийн зэргийн бүтээлүүдийн модон бар бол шол бараас эхтэй болох нь тодорхой болов. Мөн модон бар бүтээлгэхийг эртнээс нааш уйгагүй дурдсан хүн бол Тавдугаар Далай ламын түшмэл Дэвасанжаажамц байсныг тэмдэглэжээ. Төгсгөлийн үгийг бичсэн гэх Хор нутгийн Жамьянгавааашинэн гэгч бол Тавдугаар Далай лам (1617-1682) юм. 1687 он гэдэг бол Тавдугаар Далай лам аль хэдийн таалал болоод байсан үе боловч, түүний таалал болсныг Санжаажамц нууцалж байсан билээ.

Монгол орчуулгын Зонхавын сүмбүмд орсон бүтээлүүдийг жагсаасан дарааллаас төвөд эх нь бээжин барын Данжуурт дагалдах Зонхавын сүмбүм болох нь илт байна (Бурмаа, 2019: 15).

Эндээс сүмбүмийн орчуулга Их бодь мөрийн зэрэг (ZSMJ) бүтээлийн төвөд эх нь бээжин барын Ламримчэнмо, харин бээжин барын төвөд эх нь Шол

⁶¹ ces rgyal ba btsong kha pa chen po 'i bka' 'bum gsar brkos ma grub pa tshan che ba 'dug pa rnamс
gsar du brko dgos tshul gyi sde pa sangs rgyas rgya mtshos sngon nas bskul ma byung ba ltar byang
chub lam gyi rim pa 'di yang rab byung bcu gnyis pa 'i me yos kyi lo / dga' ldan phun tshogs gling
du par brko ba 'i gra bsgrigs pa 'i tshe/ zhus dag dang do dam gnyis ka byed mi yar 'brog ba dge slong
blo gros brtan pa/ rtse skor ba dge slong blo gsar mkhas pa/ bkra shis gling pa dge slong smra ba 'i
dbang phyug gsum dang / yig mkhan dga' ldan bstan 'dzin / blo bzang rab 'byor/ tshe ring dar rgyas/
brkos mkhan dbu mdzad dgos slebs/ gzhung pa rdo rje/ dpung sogs/ brag sna dbang rgyal/ rdo rje
dbang rgyal/ tshe dbang dpal ldan/ gsum dar / gtsang pa kun dga' tshe brtan/ g.yul rgyal/ lhun sdings
rdo rje/ 'dzim chung dbang po/ / dbang ldan / srung mo pad+ma rnamс dang / shing bzo bsod namс/
dbu lha 'dri(sic. 'bril' mi bzang po 'od zer/ dgos cha sprod mi rgya ma ba ngag dbang tshe ring dang
ka bzhi smad pa bsod namс nor bu rnamс kyiс ched du sgrubs pa 'i byang chub lam gyi rim pa 'bring
po 'i par byang 'di yang za hor gyi ban+de 'jam dbyangs dga' ba 'i bshes gnyen gyis sbyar ba 'i yi ge
pa ni dpal grong sngags rams pa ngag dbang dge legs kyiс bgyis pa dza yan+tu/ /

бараас эхтэй болохыг хөөж мэдэж болж байна. 7 төрлийн орчуулгын дотор төвөд эх нь тодорхой болсон нь ганц энэ сүмбүмийн орчуулга юм.

(5) Түмэдийн Лувсанцэнпэл гүүшийн орчуулга (1812)

Өвөр Монголын номын санд No.B/946/6, No.B-2/946/6 дугаартай, *Сацлал үгүй их Зонхава бээр зохиосон Их бодь мөрийн зэрэг оршой* нэрт, 2 дэвтэр, 618 судрын хуудас хэвлэл байна. Төгсгөлийн үгийг сийрүүлэв.

egüni mongyul-un kelen-dür orčiyul kemen, erkin oyutu toyin rabjamba dkon mčog bsam 'rob kiged, erdem bisilyal-tu čorji Tat pa rgya mtsho ba, erdemtū gūüsi blo bzang dbang rgyal terigūten. olan šabinar ber duradqasan-a sitüjü, olan ami-tan-i uduriduyči šasin-u ejen boluysan olan boyda blam-a nar-un ölmei-dür sitüjü olan sonusuyсан гүүсриi dga-a bču sudhi neretü-ber. öber-ün oyun-u činegen masi öčüken (616b]bolbaču, ülemji ačitu yoga cari blam-a-yin gegen-eče, öni udayan orčiyuly-a kötlbüri selte-yi sonusun, ülemji včir dhar-a 'zam dbyans bsad ba-yin gegen kiged. degedü buyan sadun dkun mčog bdhičin-u gegen-eče, degedü nom egünü nomlal??-yin kötlbüri-yi sonusuy-san ba, degedü nom egünü mön tayilburi-dur sitüjü, degedü nom egüni önide delgeregülkü-yin sanal-iyar. arban dötüger sayitur iregsen jil-ün, anggara kemegdekü qara bičin on ašuvani* sar-dur, ali čidaqui-ber tegüsgeŋ orčiyulaysan-u biči-geči inü, ariyun sanvar-tu gušri blo bcang legs bsad dar rgyas bolai. (616a19)*

nom-un yosun egüni, dayičing ulus-un törü gerel-tü-yin qoyaduyar on-u qar-a morin jil barayun tümed kiryultai-yin čimed-ün bkrasis dga'ldan chos 'khor gling keyid-dür būridken seyilejü orusiylba. (618a)

Төгсгөлийн үгэнд орчуулагдсан оны тухайд “arban dötüger sayitur iregsen jil-ün. anggara kemegdekü qara bičin on ašuvani sar-dur” гэсэн нь 1812 он, хэвлэгдсэн оныг “dayičing ulus-un törü gerel-tü-yin qoyaduyar on-u qar-a morin jil” гэсэн нь 1822 он юм (Шаркозы⁶², 2018: 547, 1366). Орчуулагч өөрийгөө гавж Суди хэмээжээ. Орчуулагч Гавж Суди гэдэг бол Лувсанцэнпэл (1761-1834) гүүш юм. Түүний намтарт *Их бодь мөрийн зэрэг* зохиолыг 1810 оноос орчуулж эхлээд, 1812 онд дуусгасан талаар тодорхой өгүүлдэг (Хай Ми⁶³, 2011: 285-288).

(6) Буриадын Галсанжамбын орчуулга (1870)

Буриадаас Дэлгэрийн Галсанжамба (1816-?) *Их бодь мөрийн зэрэг* зохиолыг орчуулсан тухайгаа өөрийн намтартаа бичиж үлдээжээ. Түүний орчуулга байх магадлалтай Агын барын *Их бодь мөрийн зэрэг* зохиолын төгсгөлийн үгийг үзвээс.

boyda btsongkhapa-yin gegen ten-ü jokiyaγsan yeke bodi mör-ün jerge-eče bodisadu-a-yin yabudal yerü-dür suralčaqi-yin üy-e kürtele ki egün-ü keb-i,

⁶² Alice Sarközi

⁶³ Qai mi

asuru ariyun šayšabad kiged, busud-i tusalaqu ülemji sedkil-ün sang boluysan smanpa khripa rinčin bzangpo (Tib. smanpa khripa rinchen bzangpo)-yin gegen ten-ber nayan nasun-dayan šasin-u yarqu-yin orun (230a] bdičin lhüngrübgling (Tib. bde chen lhung grub gling)-dür бүкүү siltayan nögücel-i nayirayulju keb-tür бүтүгелгегсен-ү keb-ün temdeg irüger selte kereg-tei kemen dga bju blobzang bsamgdan (Tib. dka bcu blo bzang bsam gten) duradqaysan-u ildar-a galpa bhadra-a ša-a sa dhar-a (Tib. kalpa bha dra sha' sa dha ra) ber nayirayulbai. (BDRC No. W1EE32. 229b16-230a11)

Нэгдүгээрт, Зонхавын *Их бодь мөрийн зэрэг* зохиолын гурван төрөлхтний бүлэг хүртэлх орчуулга болохыг дурджээ. Мөн Манбатипаренчин⁶⁴ 80 насандаа Дэчинлүндэвлин⁶⁵ сүмд бүтээлгэсэн хэвийн тэмдэг сэлтийг засах шаардлагатай хэмээн гавж Лувсансамдан⁶⁶ дурдсан тул Гарба Бхадра Шасадхара⁶⁷ найруулав гэжээ. W1EE31 нь төвөд хэлний үгс хийгээд төвөд гаралтай хүний нэр зэргийг төвөдөөр нэмж гараар бичсэн байх ба тэр дагуу W1EE32 хувилбарт засагдан барлагдсан байх ажээ. Эндээс W1EE31 бол арай түрүү үеийн хувилбар болох нь тодорхой бөгөөд W1EE32 төгсгөлийн үгэнд гарч буй өмнөх бар байх боломжтой байна.

Гарба Бхадра Шасадхара гэдэг нэр нь Буриадын Галсанжамбын одоо мэдэгдэж байгаа нэрстэй яв цав таарахгүй байна. Гэсэн хэдий ч Галсанжамба орчуулгын төгсгөлдөө тогтсон нэр гэхээсээ өөр өөр нэрээр бичиж үлдээх дуртай хүн байсан тул түүний мэдэгдээгүй нэг нэр байх ч магадлалтай. Галсанжамба 1870 онд *Их бодь мөрийн зэрэг* зохиолыг орчуулсан тухайгаа намтартаа бичиж үлдээсэн байдаг (Дамдинсүрэн, 1968: 184). *Бодь мөрийн зэрэг* гэж бичигдсэн байгаагаас их багын аль нь вэ гэдгийг намтраас нь мэдэх боломжгүй. Гэвч XIX зуунд *Их бодь мөрийн зэрэг* зохиолыг Дэлгэрийн Галсанжамба орчуулсан гэх мэдээ (Бямбаа, 1997: 33, 38) мөн бий тул энэ төгсгөлийн үгэнд гарч буй редактор Гарба Бхадра Шасадхара нь Галсанжамба мөн болов уу гэдэг таамаглалд өөрийн эрхгүй хөтөлж байна.

(7) Т.Булганы орчуулга (2004-2007)

Хамгийн сүүлийнх бол Т.Булганы 2004-2007 онд орчуулсан *Их бодь мөрийн зэрэг* 3 боть, орчин цагийн монгол хэлний орчуулга юм.

Ингээд 7 орчуулгынхаа сурвалж бичгийн мэдээллийг нэгтгэе.

(1) Алтангэрэл увшийн орчуулга (орч. он 1655)

Нэр: *yeke bodhi mör-ün jerge*.

Товчлол : АМЖ (Алтангэрэл Мөрийн зэрэг)

⁶⁴ sman pa khri pa rin chen bzang po

⁶⁵ bde chen lhung grub gling

⁶⁶ blo bzang bsam gten

⁶⁷ kalpa bha dra sha' sa dha ra

Байршил : Монголын Үндэсний номын сан No.4049/96

Нөхцөл : Цахим хэлбэрээр үзэх боломжтой (378 судрын хуудас)

Бичээчийн үзсэн байдал : 1b, 377b, 378a хуудсыг 2018 оны 8 сард галиглаж авав.

(2) Зая бандидын шавь Дагийн орчуулга (орч. он 1662-1670)

Нэр: тодорхойгүй

Товчлол : DMJ (Зая бандидын шавь Даги, Mong. rab 'byam Ĵa ya-yin eġüs šabi Daki)

Байршил : тодорхойгүй

Нөхцөл : үзэх боломжгүй (59,7×15,5 см, 471 судрын хуудас)

Бичээчийн үзсэн байдал: Үзэж байгаагүй.

(2a) Ховд гар бичмэл тодын орчуулга

Нэр: тодорхойгүй, орчуулагч, орчуулагдсан огноо тодорхойгүй

Товчлол : НМJ

Байршил : тодорхойгүй (фото эх нь Ховд их сургуулийн багш Батсуурь агсанд байсан)

Нөхцөл : үзэх боломжгүй (233 судрын хуудас)

Бичээчийн үзсэн байдал : Эхний 5, сүүлийн 2 хуудсыг фото эхээр үзэв.

(3) Урадын мэргэн равжамба Гунгаажамцын орчуулга (1654-1703)

Нэр: *lamrimġimu*.

Товчлол : КМJ (Mong. rab 'byams pa kün dga' rgya mtsho)

Байршил : (3a) Өвөрмонголын номын сан No.B/209-1/1~10

(3b) Уг эх Өвөрмонголын Шашны нийгэмлэгийн номын санд бий гэх ч байгаагүй.

(3c) Хятадын Үндэсний ордон музейн номын сан⁶⁸ 1667 оны модон барын орчуулгаар хадгалагдаж байна (26 мөр, 63.7×22.1, 50.7×14.4 см 694).

Нөхцөл : (3a) буюу 1986 онд хуулсан дээрх гар бичмэл 10 дэвтрээс үзэх боломжтой.

Бичээчийн үзсэн байдал : (3a)-ын эхнээс нь 5, сүүлээс нь 5 хуудас.

(4) Зонхавын сүмбүм дэх орчуулга (орч. он 1730 оны сүүл хагас)

Нэр: *ilayun-san-u sayin jarliy бүгүде-yin onisun-i quriyaysan yurban törülkiten-iyer angqar-un abaqu-yin jerge бүгүде-yig бүрин-e үјүгүлүgsen yeke bodhi mör-ün jerge-yin yabudal yerü-yin surtaqun-aġa degegeši kiged, duyan-yin mön ġinar amurlin aqui-dur yambar metü surulġaqu-yin yosun nomlal kemekü*. Орчуулагч тодорхойгүй.

Товчлол : ZSMJ

Байршил : (4) Ganjuur Danjuur (2014). Энэ хэвлэл *Бага бодь мөрийн зэрэг* дутуу тул 3 төрөлхтний бүлгээ “ka” (Хар үсгийн сүмбүмээр бол 1a-386a) vol. 1,

⁶⁸ National Palace Museum Library (故宫博物院图书馆 No. 宗 23658)

Үлэмж үзэхүйн бүлгээ “kha” (1a-204a) vol. 2 болгон оруулжээ. Уг нь бол Зонхавын сүмбүмд *Их бодь мөрийн зэрэг* нэгдүгээр боть болон орсон байдаг.

(4a) Японы Тоуо Bunko номын санд 3 хувь байна. MO2-07-11,13,16+24 (3 төрөлхтний бүлэг MO2-07-13, Үлэмж үзэхүйн бүлэг MO2-07-24 нь тус тус дугаарлагдсан)

(4b) Оросын Санкт-Петербург хотын номын санд No. 2.116-128 дугаартай сүмбүм бий.

(4c) Өвөр Монголын Номын санд No.49.3/22 дугаартай бага оврын сүмбүмийн ботиор байна.

(4d) BDRC No. W1EE1 *yeke bodhi mör-ün jerge* бол агуулга ижил өөр барын текст юм⁶⁹. 3 төрөлхтний бүлэг бөгөөд 41 мөр бүхий 316 хуудастай.

(4e) Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Н.Амгаланд *yeke bodhi mör-ün jerge orusiba* гарчигтай, 22 мөр бүхий, 548 судрын хуудас шунхан гар бичмэл⁷⁰ байна.

Нөхцөл : Дээрх эхүүдээс үзэх боломжтой.

Бичээчийн үзсэн байдал : үзсэн.

(5) Лувсанцэнпэлийн орчуулга (орч. он 1812)

Нэр: *Сацлал үгүй их Зонхава бээр зохиосон Их бодь мөрийн зэрэг оршвой*
Товчлол : LMJ

Байршил : Өвөр Монголын их сургуулийн номын сан No.B/946/6, No.B-2/946/6

Нөхцөл : Хөх хотын номын дэлгүүрт зарагддаг, үзэх боломжтой түгээмэл текст.

Бичээчийн үзсэн байдал : үзсэн.

(6) Галсанжамбын орчуулга (1816-18??) (орч. он 1870)

Нэр: *sačalal ügei yeke zongkha ba-yin jokiya yeke bodi mör-ün jerge orusiba*.
Товчлол : GMJ

Байршил : (6a) BDRC No. W1EE31 Төгсгөлийн үггүй, 37 мөр, 269 судрын хуудас бар.

⁶⁹ Ганжуур, Данжуур (2014)-аас үзэх боломжтой. Үнэндээ бол хар үсгийн Зонхавын сүмбүмийн нэгдүгээр боть болох *Их бодь мөрийн зэрэг* нь бар сийлбэрчний алдаанаас үүдсэн нэгэн онцлогтой. Тэр нь юу вэ гэхээр 103b нүүрэнд дэх агуулга орох газар 104b, 104a орох газар 103a нүүрний агуулга орсноос 103a-104a хоорондох текст нь (102b → 104a → 103b → 103a → 104b → 105a] ард урдаа орсон байдаг. BDRC No. W1EE1 мөн уг алдаа байх ба 102b нүүрний төгсгөлд хас тэмдэг, 104a нүүрний эхэнд хас тэмдэг, төгсгөлд нь нүдний шилний тэмдэг, 104b нүүрний төгсгөлд тэнцүү тэмдэг, 103a нүүрний төгсгөлд тэнцүү тэмдэг, 103b нүүрний төгсгөлд нүдний шилний тэмдэг тус тус тавих замаар 105a нүүртэй золгуулжээ.

⁷⁰ Мөн гурван төрөлхтний бүлэг хүртэлх текст бөгөөд Зонхавын сүмбүм дэх барын алдааг мөн адил 148a19-150b9 хуудасны хооронд давтаж байгаагаас сүмбүмийн бараас хуулсан эх болох нь тодорхой байна. ZSMJ.102b нүүрний агуулгатай дүйх хэсэг болох 148a19 мөрний төгсгөлд чандмань эрдэнэ мэт 3 дусал оруулан, буцаах тэмдгийг нь ZSMJ. 104a нүүрний агуулгатай дүйх хэсэг болох 149a21 мөрөнд гараар нэмж бичиж өгчээ.

(6b) BDRC No. W1EE32

- Буяндэлгэр Г. (2014). *Их бодь мөрийн зэрэг. Гурван төрөлхтний мөрийн зэрэг*. Улаанбаатар: Цогт цагийн хүрдэн төв, Мөнхийн үсэг ХХК-д хэвлэв⁷¹. (425 хуудас)
- Гандантэгчэнлин хийд (2020). Хэмжээ 41,5×9,5 (30×6,5] см, 30 мөр, 231 судрын хуудастай. BDRC No. W1EE32-тэй дүйх тесктийг ямар нэгэн оршил тайлбаргүйгээр судар хэлбэрээр дахин принтерлэж гаргасан хэвлэл юм.

Нөхцөл : BDRC No. W1EE32, W1EE31, Буяндэлгэр Г. (2014), Гандантэгчэнлин хийд (2020)-ийн текстүүдээр үзэх боломжтой. Гурван төрөлхтний бүлэг хүртэлх агуулга.

Бичээчийн үзсэн байдал : үзсэн.

(7) Булганы орчуулга (1959~) (орч. он 2004-2007)

Нэр: *Их бодь мөрийн зэрэг*.

Товчлол : BMJ

Байршил : <http://www.buddhism.mn> сайтад PDF хэлбэрээр бий.

Булган Т. (2004) Зонхава Лувсандагва *Бага ба дунд төрөлхтний мөр*. I дэвтэр.

Булган Т. (2006) Зонхава Лувсандагва *Их төрөлхтний мөр*. II дэвтэр.

Булган Т. (2006) Зонхава Лувсандагва *Амарлингуй оршихуй ба үлэмж үзэхүй ухаан*. III дэвтэр.

Нөхцөл : Дээрх 3 дэвтрээр үзэх боломжтой.

Бичээчийн үзсэн байдал : Үзсэн.

3.2. Орчуулгуудын мөргөлийн шүлгийн харьцуулалт

Зөвхөн эхний хэсэг буюу мөргөлийн шүлгээр харьцуулаад орчуулгыг бүхэлд нь дүгнэх учир дутагдалтай хэдий ч орчуулгуудын хоорондын харилцан нөлөө хийгээд бие даасан байдал зэргийг ерөнхийд нь харахын тулд төвөд эх, 7 орчуулгын эхний хэсэг болох мөргөлийн шүлгийг харьцуулав.

(1) Алтангэрэл увшийн орчуулга (1655)

(3) Урадын мэргэн гэгээн Гунгаажамцын орчуулга (1654-1703)

(5) Лувсанцэнпэлийн орчуулга (1812)

(7) Т.Булганы орчуулга (2004-2007) эдгээр 4 орчуулгын хувьд орчуулагч, орчуулагдсан он зэрэг тодорхой бий тул бие даасан орчуулгууд гэдэгтэй маргах газаргүй. Дээрээс нь (2а) Ховд тод гар бичмэл угаас нутгийн аялгуу хийгээд тод үсгийн онцлогийг шингээсэн ялгарах онцлог бүхий орчуулга харагдаж байлаа.

Галсанжамбын орчуулга (1870) нь Лувсанцэнпэлийн орчуулга (1812), Сүмбүмийн орчуулга (1730-аад оны сүүлч), Гунгаажамцын орчуулга (XVII

⁷¹ Энд 1906 оны Агын бар гэж бичсэн байх авч тодорхой үндэслэл дурдсангүй.

зуун) эдгээр 3 орчуулгыг харж хийжээ гэхээр байна. Ялангуяа Лувсанцэнпэлийн орчуулгын нэрийг бараг тэр чигээр нь авч тавьсан байгаа байдал хийгээд Галсанжамбаар нэр тохоож байгаа Гарба Бхадра Шасадхара нь өөрийгөө орчуулагч бус редактор гэж дурдсаныг харгалзан үзвэл бие даасан орчуулга гэж үзэх нь зохистой эсэхийг нягтлах шаардлага мөн гарч ирж байна. Тэхээр Галсанжамбын гэх тусдаа орчуулга бас оршин байдаг уу, бичээч надаас гадна хойш хойшдын судлаачид энэ асуудлыг анхааралдаа авч тодруулах болтугай. Гэвч үг үсгийн зөрүү яах аргагүй байгаа тул орчуулгуудаа хооронд нь ялгах үүднээс энд Галсанжамбын орчуулга гэдгээр явъя. Өөрөөр хэлбэл сүмбүм, Лувсанцэнпэл, Галсанжамбын гэх 3 орчуулгад Гунгаажамцын орчуулгын нөлөө байна. Нөгөөтгээгүүр Алтангэрэлийн орчуулга (1655), Ховд гар бичмэл тодын орчуулга, Гунгаажамц орчуулгуудыг зөвхөн мөргөлийн шүлгээр нь харилцан нөлөөлөл гэх зүйл тодруулж чадсангүй. Булган орчуулга бол мөргөлийн шүлгийн тухайд толгой холбосон, агуулгын хувьд утгачилсан гэх мэт онцлог бүхий байх ба ерөнхийдөө энэ орчуулга бусад уламжлалт орчуулгуудаас нэлээд бие даасан байдалтай болжээ.

Зонхавын сүмбүмийн орчуулга өмнөх орчуулгуудынхаа дундаас Гунгаажамцын орчуулгыг шууд авч оруулсан байх боломжтой байна. Гэхдээ бичээч миний бие Гунгаажамцын орчуулгаас цөөн хэдэн хуудсыг үзэж танилцсан тул эцэслэн өгүүлэхээр яарахгүй байна. Гэвч мөргөлийн шүлгээр бол яах аргагүй ялгаа гэж болохоор үг хийгээд дагавар нөхцөлийн ондоошил бий тул тус тусад нь авч үзлээ. Орчуулгуудын дотроос Зонхавын сүмбүмийн орчуулга хамгийн өргөн дэлгэр тархжээ. Энэ нь яах аргагүй Зонхавын сүмбүмийг Данжуурт дагуулж барласны үр дүн гэлтэй.

4. Дүгнэлт

Энд *Их бодь мөрийн зэрэг* зохиолын монгол орчуулгын материалыг чадах чинээгээр цуглуулж судлан, төгсгөлийн үг ба түүхэн баримтад тулгуурлан орчуулагдсан огноог тус тус тодруулав. Бүх орчуулгын эхний хэсэг буюу мөргөлийн шүлгээр, тэр дундаа орчуулагч нь тодорхойгүй гар бичмэлүүдийг харьцуулж, тухайн эх нь орчуулгын аль төрөлд хамаарахыг тодруулснаар нийт 7 зүйл орчуулга байгааг олж тогтоолоо. Тэрхүү үр дүнгээ ойлгомжтой болгох үүднээс сурвалж бичгийн мэдээ болгон дахин эмхэтгэв. Мөн Зонхавын сүмбүмийн орчуулга *Их бодь мөрийн зэрэг* (ZSMJ) бүтээлийн төвөд эх нь бээжин барын Ламримченмо (1724), харин бээжин барын төвөд эх нь Шол бараас эхтэй болохыг хөөж мэдлээ. Зонхавын сүмбүмд орсон орчуулга *Их бодь мөрийн зэрэг* (1730 оны сүүл хагас), Лувсанцэнпэл (1812), Галсанжамба (1870) нарын орчуулгад Гунгаажамцын орчуулга нөлөөлжээ гэхээр байна.

Ном зүй

Ашигласан эх материал

lam rim chen mo (Kyt1/2] Tsong kha pa blo bzang grags pa: *rje tsong kha pa'i lam rim chen mo'i lung khungs gsal byed nyi ma'i stod cha*. Critically edited by Tsultrim kelsang khangkar. Japanese and Tibetan Buddhist culture Series.VI,VII Tibetan Buddhist Culture Association, 2001-2004. [尊者ツォンカパの『菩提道次第大論』上下巻、ツルティム・ケサン校訂、日藏仏教文化叢書 6-7 寿徳寺文庫, 第 34, 38 巻 2001-2004 年]

AMJ *yeke bodhi mör-ün jerge*. Алтангэрэл увшийн орчуулга *Их бодь мөрийн зэрэг*. 378 хуудас гар бичмэл, Монгол Улсын Үндэсний төв номын сан No.4049/96.

DMJ Зая бандидын отгон шавь Даги (Rab 'byam Ĵa ya-yin eċüs šabi Daki) орчуулсан *Их бодь мөрийн зэрэг*.

HKMJ Ховд Их Сургуулийн Номын Санд хадгалагдаж байсан “*yeke töröl-kitüin zamayin nomalasan küsekü setkil sudulqutai ilayuyusan köükeni yürü-yin yabudal-du surqu zamayin ulami nomloċi dūsba*” гэх төгсгөлийн үгтэй 233 хуудас тод үсгийн бар.

KMJ *lamrimċimu* хэмээн хавтсан дээрээ уйгуржин монголоор бичсэн 1986 оны гар бичгийн хуулбар эх Өвөр Монголын Номын Сан (内蒙古圖書館)-д No.B/209-1/1-ээс 10 дэвтэр хадгалагдаж байна. 'bro ba mergen Rab 'byams pa Kün dga 'rgya mtsho-ын орчуулга болох үүний жинхэнэ эх нь Өвөр Монголын Бурхны Шашны Нийгэмлэгийн Номын Сан (内蒙古佛教协会圖書)-д бий гэх.

ZSMJ *ilyuyusan-u sayin ĵarliĵ bügüd-yin onisun-i quriyaysan ĵurban törülkiten-yer angqar-un abqu-yin jerge bügüd-yi būrin üĵügülgügen yeke bodhi mör-yin jerge-yin yabudal yerü-yin surtaqun-aċa degegsi kiged diyan-u mön ċanar amurlin aqui-dur yambar metü surulċaqu-yin yosun nomlal kemekü*. Mongĵol 《Ганĵуур • Данĵуур》-un foto keblel. Zongkhaba yin süngbüm tergün boti. Kökeqota: Öber Mongĵol-un arad-un keblel-ün qoriy-a, 2014.

LMJ *saċalal ügei yeke bzungkha ba ber ĵokiyaysan yeke bodhi mör-ün jerge orusiba*. хэмээх Гавж Суди (dga-a bċu sudhi) нэргийн орчуулга болох *Их бодь мөрийн зэрэг*. Өвөр монголын номын сан(内蒙古圖書館)-д No.B/946/6 ба B-2/946/6 дугаарын 2 дэвтэрт, 618 хуудаст судрын фото зургийн орчин цагийн хэвлэл хэлбэрээр хадгалагдаж байна.

GMJ *saċalal ügei yeke Zongkha ba-yin ĵokiyal yeke bodi mör-ün jerge orusiba*. BDRC No. W1EE32, W1EE31, Буяндэлгэр Г. (2014), Гандан (2020).

Ганĵуур • Данĵуур (1914). Mongĵol 《Ганĵуур • Данĵуур 1947》-un foto keblel. Данĵуур ĵarċay boti. Kökeqota: Öbür Mongĵol-un arad-un keblel-ün qoriy-a.

Толь бичиг

MGO (1742). *merged yarqu-yin orun*. Доорх хоёрын *ᠵᠣᠷᠢᠶᠲᠤ* 1988 **【MGO-a】** нь *Dag yig mkhas pa'i 'byung gnas* ба *merged yarqu-yin orun*-ны орчин цагийн дэвтэрлэсэн хэвлэл бол *Rasisereng* 2011 **【MGO-b】** нь төвөд монгол цагаан толгойн дараалалд оруулсан хэвлэл болохоороо ялгаатай агуулга нэг бүтээлүүд болно.

ᠵᠣᠷᠢᠶᠲᠤ. (1988). **【MGO-a】** *ᠵᠠᠮᠠᠶᠠᠨᠲᠦᠪᠳᠡᠨ ᠵᠣᠷᠢᠶᠲᠤ: Merged garaqu-yin oron*. *ᠵᠠᠩᠭᠢᠶᠠ-ᠰᠢᠳᠠᠨᠪᠢᠣᠷᠠᠮᠪᠠ ᠵᠣᠭᠢᠶᠠᠪᠠ*. *begejing: ündüsün-ü keblel-ün qoriy-a*. (嘉木樣圖布丹·卓日格圖『智慧之源』北京)

Rasisereng. (2011). **【MGO-b】** *G. Rasisereng nayirulan zokiyaba: oyun-i todurquiluyči erdeni erike /Tib. blo gsal rin chen phreng ba*. *degedu, dooradu debter. kökeqota: öber mongyul-un keblel-ün bülügöl öber mongyul-un soyul-un keblel-ün qoriy-a*. (格·拉西色楞『明慧寶鬘』呼和浩特 内蒙古文化出版社)

Fukuda Yoichi, Ishihama Yumiko. (1989). **【Mahāyutpatti】** *A New Critical Edition of Mahāyutpatti*. Sanskrit-Tibetan-Mongolian Dictionary of buddist terminology. (新訂翻訳名義大集) *Materials for Tibetan-Mongolian Dictionaries*, Vol.1 Tokyo: The Toyo Bunko.

Ishikawa Mie. (1993). *Mahāyutpatti-ын хэцүү үгийн тайлбар*. 『二卷本訳語釈 一和訳と注釈一』東洋文庫 STUDIA TIBETICA No.28, *Materials for Tibetan-Mongolian Dictionaries*, Vol.3.

Alice Sarközi. (2018). **【Sumatiratna】** *Sumatiratna Tibetan-Mongolian Explanatory Dictionary with English Equivalents and Index of Mongolian Words*. Ulaanbaatar: Published by the International Association for Mongol Studies, Classical Mongolian Studies-I.

Каталог

Tibetan Tripitaka Peking Edition. (1962). Edited by Dr. Daisetz, T. Suzuki. *Catalogue Tibetan Tripitaka Peking Edition*. - Kept in the library of the Otani University, Kyoto. - Reprinted under the supervision of the Otani University. Tokyo: Suzuki Research Foundation.

Uspensky, Inoue. (2001). *Uspensky Vladimir L, Osamu Inoue*. Edited by Tatsuo Nakami. *Catalogue of the Mongolian Manuscripts and Xylographs in the St. Petersburg State University Library*. Tokyo: Institute for the study of Languages and Cultural of Asia and Africa.

Ашигласан ном

Бурмаа А. (2019). Монгол хэл дээрх Богд Зонхавын сүмбүмийн 2 бар. *Research report of the Graduate School of Otani University*. No.36, 3-18. 「モンゴル語訳ツォンカパ全集の二つの版」『大谷大学大学院研究紀要』第36号 pp. 3-18.

Бурмаа А. (2020). Жанжаа хутагтын *Мэргэд гарахын орон* зохиолын онцлог. *Япон Монгол сэтгүүл*. No.54 (1,2) 172-189. 「チャンキヤ著『正字法・賢者の源』の特徴 — 『二巻本訳語釈』との比較を通じて—」『日本とモンゴル』第54巻第1号・第2号合併号 (139号・140号合併号) pp. 172-189.

Буяндэлгэр Г. (2014). *Их бодь мөрийн зэрэг. Гурван төрөлхтний мөрийн зэрэг. Улаанбаатар: Цогт цагийн хүрдэн төв, Мөнхийн үсэг ХХК-д хэвлэв. (Уг эх нь Буриадын Агийн дацангийн 1906 модон бар)*

Бямбаа, Р. (1997). “Зонховын Ламрим Чен Бо (Лам-Rim-Chen-Po) дахь алдаа мэдгийг Агваанбалдан зассан нь”. *Лавайн эгшиг*. Улаанбаатар: Гандантэгчэнлин хийд. 33-38.

Ганзориг, Д., Бямбаа Р. (2017). *Монголчуудын Ганжууртай холбоотой ном бүтээлийн өв*. Арван долоодугаар зууны үеийн Халхын алдартай орчуулагч Алтангэрэл увшийн орчуулсан “Ихэд тонилгогч” хэмээх судар оршвой. Монгол билэг төв.

Дамдинсүрэн, Ц. (1968). *Монголын уран зохиолын тойм. III дэвтэр*. Улаанбаатар: БНМАУ-ын Шинжлэх ухааны академи Хэл зохиолын хүрээлэн. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо.

Дамдинсүрэн, Ц. (1984). *Монголын уран зохиолын өв уламжлалын асуудалд*. Шинжлэх ухааны академийн хэвлэл.

Лувсанбалдан, Х. (1975). *Тод үсэг түүний дурсгалууд*. БНМАУ, Шинжлэх ухааны академи хэл зохиолын хүрээлэн.

Ядамжав, Г. (2017). *Бодь мөрийн үе оршвой*. Улаанбаатар: Тод номын гэрэл төв.

Sečenbileg, S. (2017). “Mongyul 《ᠶᠠᠨᠵᠢᠭᠦᠷ》-un orčiγuly-a ba bar keblel-ün teüken toyimu” *Монгол Ганжуур Олон улсын судалгаа*. Улаанбаатар: Шинжлэх ухааны академи түүх археологийн хүрээлэн. 117-134.

Sečenbileg, S. (2018). “Urad-un mergen Rabjamba Küngyājamsu ba tegün-ü jokiyaḷ bütügel” *Urad soyul sudulal*. Gün uqayan neyigem-ün sinjilekü uqayan, Bayannaγur qota-yin urad soyul sudulān-u neyigemlig.

Qai mi. (2011). “Lubsangčempil-un namtar sudulul” - čayan lingu-a-yin erike-yin orčiγuly-a tayilburi ba angqan-u sinjilel. töb-ün ündüsüten-ü yeke suryayuli-yin doktor-un jerge qamayalaqu ögülel, mongyul kele udq-a jokiyaḷ-un salburi, jiluyuduyči bayši Öljeyibayar.

bstan pa bstan 'dzin. (2003). *chos sde chen po dpal ldan 'bras spungs bkra shis sgo mang grwa tshang gi chos 'byung dung gyas su 'khyil ba'i sgra dbyangs. mundgod, distt. north kanara karnataka: Publisher dpal ldan 'bras spungs bkra shis sgo mang dpe mdzod khang. Vol.1 / BDRC work No.28810.*



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.